

МОНГОЛЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБОО

# ХҮРЭЛТОГООТ-2011 ХӨДӨӨ АЖ АХУЙ – БИОТЕХНОЛОГИЙН САЛБАР

ЭМХЭТГЭЛҮҮДИЙН  
ХУРААНГУЙ  
SUMMARY

## ГАРЧИГ

- **Сожид-11 эмийн антибиотик төст чанарыг судалсан судалгаа**  
А.Төгөлдөр, (ph.d) Б.Нарангэрэл  
УАШУТҮК-ийн Уламжлалт Эмийн Үйлдвэр, Мал Эмнэлгийн Хүрээлэн  
И-мэйл: atogoldor@yahoo.com
- **Боомын нян (*bacillus anthracis*)-ийн эсрэг хар мод (*larix sibirica* ldb.)-ны мөчрийн идэвхт нэгдлийн судалгаа**  
П.Эрдэнэбаатар, Ж.Батхүү, Д.Ганболд, Ш.Оюунцэцэг,  
Д.Отгонбаатар, Д.Цэрэнпоров, Г.Одонгуяа  
ШУА, Биологийн Хүрээлэн, МУИС, Биологи-Биотехнологийн Сургууль  
Байгалийн Голомтот Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв  
ШУА, Хими-Хими Технологийн Хүрээлэн
- **Олон цэцэгт сухай (*tamarix ramosissima* L.)-н биологийн нөөцийг биотехнологийн аргаар нэмэгдүүлэх боломж**  
Ц.Мөнхцэцэг, Ю.Оюунбилэг  
ШУА, Биологийн хүрээлэн, Ургамлын эсийн өсгөврийн лаборатори  
И-мэйл: Munkhуu003@yahoo.com
- **Дундад халхын хээрт ургамлын бүрхэц, тохиолдоц, зүйлийн бүрдлийг даубенмайрын аргаар тодорхойлох судалгаа**  
(Төв аймгийн Баян, Баянцагаан сумын жишээн дээр)  
И.Сарангэрэл  
Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв
- **Бэлчээрийн мониторингийн судалгааны дүнгээс(ойт хээрийн бүс)**  
Ж.Гангуяа  
М.А.А.Э.Ш.Х,  
И-мэйл: gant\_416@yahoo.com
- **Монгол орны зарим зүйл ургамлын мутагений болон бактерийн эсрэг идэвхийн скрининг судалгаа**  
Ж.Удаахбаяр, Ч.Батцэцэг, Ж.Батхүү  
Монгол Улсын Их Сургуулийн Биологи Биотехнологийн Сургууль  
И-мэйл: Udaah\_09@yahoo.com
- **Дөрвөлжин сум орчмын ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тэдгээрийг хуурайшилтын илтгүүрт ашиглах нь**  
Х.Солонго  
Ботаникийн хүрээлэн. Ургамлын аймаг, ангилалзүйн салбар  
И-мэйл: khadaas@yahoo.com
- **Монгол орны *cetraria islandica* (L) ach. Хагийн зарим бактерийн эсрэг идэвхийн судалгаа**

Г. Мөнхцацрал, Б. Мөнхжаргал

<sup>1</sup>ШУТИС-ийн Хүнсний Инженер Биотехнологийн Сургууль,

<sup>2</sup>ШУА-ийн Ботаникийн Хүрээлэн

И-мэйл: gmunkhtsataral@yahoo.com

- **Цэнхэр шаазгайн (*cyanopectera cyanus pallas, 1776*) үржил, түүнд ойн түймэр, зарим амьтдаас үзүүлэх нөлөө**

Б.Гантулга, С.Гомбобаатар, Kerry-Jayne Wilson, Michael Muehlenberg

МУИС, Биологийн факультет, Шувуу судлалын лаборатори,  
Ecology Department, Lincoln University, P.O. Box 84, Lincoln, New Zealand

<sup>3</sup>Centre for Nature Conservation, University of Geottingen, Germany

И-мэйл: B.Gantulga\_mos@yahoo.com, info@mos.mn

- **Монгол орны дорнод хэсгийн хошуу галууны (*anser cygnoides L., 1758*) үржлийн үеийн экологи, нүүдэл**

Ц.Мөнхзул

Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

- **A possibility to determine the age of mongolian wild ass (*equus hemionus pallas, 1775*) by annual rings in tooth cementum**

D.LKHAGVASUREN<sup>1</sup>, H. ANSORGE<sup>3</sup>, N. BATSAIKHAN<sup>2</sup>, R. SAMIYA<sup>2</sup>, A.STUBBE<sup>4</sup> AND M.STUBBE<sup>4</sup>,

<sup>1</sup>Department of Ecology, School of Biology and Biotechnology, National University of Mongolia, PO-Box 377 Ulaanbaatar 210646. e-mail: Lkhagvasuren@num.edu.mn

<sup>2</sup>Department of Zoology, School of Biology and Biotechnology, National University of Mongolia, PO-Box 377 Ulaanbaatar 210646. e-mail: Batsaikhan@num.edu.mn, Samiya@num.edu.mn

<sup>3</sup>Senckenberg Museum of Natural History Goerlitz, PF 300154 D-02806 Goerlitz, Germany, e-mail: Hermann.Ansorge@senckenberg.de

<sup>4</sup>Institute of Zoology, Martin-Luther University of Halle Wittenberg, Domplatz 4, D-06099 Halle/Saale, Germany. e-mail: stubbe@zoologie.uni-halle.de

- **Генетикийн аргаар мазаалай баавгайн тоо толгойг тогтоосон судалгаа**

Одбаяр.Т<sup>1</sup>, Майкаел Проктор<sup>2</sup>, Туяа.Ц<sup>3</sup>, Харри Рейнолдс<sup>4</sup>, Амгалан.Л<sup>1</sup>, Мижиддорж.Б<sup>5</sup>, Дерек Крайгхид<sup>6</sup>, Нямбаяр.Я<sup>5</sup>, Давид Паеткау<sup>7</sup>

<sup>1</sup>Шинжлэх Ухааны Академийн Биологийн Хүрээлэн, <sup>2</sup>Баавгай Судлал Менежементийн Олон Улсын Нийгэмлэг, <sup>3</sup>НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Байгаль Орчны Засаглалын бэхжүүлэх төсөл, <sup>4</sup>Reynolds Alaska Wildlife Associates болон Баавгай Судлал Менежементийн Олон Улсын Нийгэмлэг, <sup>5</sup>Говийн Их Дархан Цаазат Газар Хамгаалалтын Захиргаа, <sup>6</sup>Крайгхид Өмнөд Беринг;

<sup>7</sup>Зэрлэг Амьтны Генетикийн Олон Улсын Судалгааны Төв

И-мэйл: odko2008@yahoo.com

- **Буурны бохинд тестостерон даавар тодорхойлсон дүн**  
Б.Хоролмаа<sup>1</sup>, С.Цэрэнчимэд<sup>2</sup>, С.Бүрэнжаргал<sup>3</sup>, Ц.Энхтуяа<sup>2</sup>, Х.Дэлгэр<sup>2</sup>, Д.Энэбинг<sup>4</sup>

<sup>1</sup>Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, <sup>2</sup>УМАЦТЛ

<sup>3</sup>Мал эмнэлэг, биотехнологийн сургууль, ХААИС, <sup>4</sup>Био-Анагаахын сургууль, ЭМШУИС

И-мэйл: horloo\_eyes@yahoo.com

- **Гэрийн хар ялаанаас зарим эмгэг төрүүлэгч бактерийг pcr болон lamp-аар илрүүлсэн дүн**

Алимаа Цагаан<sup>1</sup>, Хиротака Капука<sup>2</sup>, Киюши Окода<sup>2</sup>

<sup>1</sup>Мал эмнэлгийн хүрээлэн

<sup>2</sup>Обихирогийн Хөдөө Аж Ахуй, Мал Эмнэлгийн сургууль

- **Ангуучин *calosoma web.* Төрлийн цохын морфологи, биологийг судалсан дүн**

С.Дорждэрэм, Ч.Чулуунжав

Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн

- **Гаршуулж буй хүдэр (*moschus moschiferus*)-ийн орооны үеийн зан төрх**

Д.Идэрбат<sup>1,2</sup>, З.Ариуна<sup>1</sup>, Р.Самъяа<sup>2</sup>

<sup>1</sup>Уламжлалт Анагаахын Шинжлэх Ухаан Технологи Үйлдвэрлэлийн Корпораци

<sup>2</sup>Монгол Улсын Их Сургууль

И-мэйл: d\_iderbat@yahoo.com

- **Монгол Үнээнд гүн хөлдөөсөн хөврөл шилжүүлэн суулгасан ажлын үр дүн**

Г.Энхманлай, Т.Балдан

ХААИС-ийн БНМСургууль

И-мэйл: Emi\_emn@yahoo.com

- **Галзуу өвчний үүсгэгчийг хоёр шаттай урвуу шуг-р оношлосон дүн**

Б.Ундармаа<sup>1</sup>, Д.Баярлахва<sup>2</sup>, Ц.Пүрэвхүү<sup>3</sup>

<sup>1</sup>ХААИС-ийн багш, MSc, <sup>2</sup>МУИС-ийн багш PhD, профессор,

<sup>3</sup>ХХААЯ-ны мэргэжилтэн PhD

И-мэйл: Undrah\_76@yahoo.com

- ***Brevibacterium marinopiscosum*-ийн өсгөвөрлөх ферментацийн тохиромжтой нөхцлийг тогтоосон дүн**

З.Эрдэнэ<sup>1</sup>, Х.Алтанцэцэг<sup>2</sup>, Jong-Bang Eun<sup>3</sup>

<sup>1,2</sup> Биологийн нөөцийн менежментийн сургууль, ХААИС

<sup>3</sup>Хүнсний микробиологи, биотехнологи, Чанномын Их Сургууль

И-мэйл: erdene\_0904@yahoo.com

- **2011 оны боом өвчний гаралтад хийсэн шинжилгээ**

Б. Даваасүрэн, Ж. Энхтуяа Б. Хурибаатар Б. Батцэцэг

МЭХ

И-мэйл: davlag\_mgl@yahoo.com

- **Зэс дутлын үеийн биохимийн зарим үзүүлэлтийн өөрчлөлтийг цус багадлын эмгэг загвар үүсгэн туршсан дүнгээс**

Д.Будрагчаа<sup>1</sup>, Т.Энх-Оюун<sup>1</sup>, М.Баянмөнх<sup>1</sup>, Ж.Батжаргал<sup>2</sup>

ХААИС-МЭХ, Бодис солилцоо, биохимийн лаборатори<sup>1</sup>  
МУИС, Биологи, Биотехнологийн Сургууль, Биохими, Биоорганик химийн тэнхим<sup>2</sup>  
И-мэйл: d.budragchaa@yahoo.com

- **Сибирийн чацаргана, үхрийн нүдийг Улаангомьн Агронаркад тариалж байгаа туршилтын үр дүнгээс**

Ж.Баасанжав<sup>1</sup>, Д. Тогтохбаяр<sup>2</sup>

<sup>1</sup>Өвөр Монголын Их сургуулийн докторант

<sup>2</sup>Монголын Алтай Соёны төслийн Увс аймаг дахь зохицуулагч

- **Эмийн багваахайгаас (*taraxacum officinale wigg.s.l*) ялгасан пальмитиний хүчлийн элэгний хорт Хавдрын эсэд үзүүлэх нөлөө**

Ж.Болдбаатар<sup>1</sup>, Г.Номинтуяа<sup>1</sup>, Ж.Тэмүүжин<sup>1</sup>, Г.Одонтуяа<sup>2</sup>, Ц.Оюунсүрэн<sup>1</sup>

<sup>1</sup>Шинжлэх ухааны академи, Биологийн хүрээлэн, Молекул биологийн лаборатори

<sup>2</sup>Шинжлэх ухааны академи, Хими хими-технологийн хүрээлэн, Байгалийн нэгдлийн химийн лаборатори

- **Influence of *taraxacum officinale.wigg.s.l* derived ingredients On liver cancer cells**

J.Boldbaatar<sup>1</sup>, G.Nomintuya<sup>1</sup>, J.Temuujin<sup>1</sup>, G.Odontuya<sup>2</sup>, Ts.Oyunsuren<sup>1</sup>

<sup>1</sup>Laboratory of Molecular Biology, Institute of Biology, MAS

<sup>2</sup>Laboratory of Nature product chemistry Institute of Chemistry and Chemical Technology, MAS

Email: boogoo506@yahoo.com

## СОЖИД-11 ЭМИЙН АНТИБИОТИК ТӨСТ ЧАНАРЫГ СУДАЛСАН СУДАЛГАА

А.Төгөлдөр, (Ph.D) Б.Нарангэрэл  
УАШУТҮК-ийн Уламжлалт Эмийн Үйлдвэр, Мал Эмнэлгийн Хүрээлэн  
И-мэйл: atogoldor@yahoo.com

**Оршил:** Манай улсад сүүлийн жилүүдэд байгалийн гаралтай буюу уламжлалт анагаах ухааны эм, танг үйлдвэрлэн хэрэглэх явдал улам бүр нэмэгдсээр байна.

Уламжлалт эм, тангийн аюулгүй байдал, үр дүнтэй, чанартай байдлыг баталгаажуулах шаардлага өсч байгаа ч уламжлалт эм, тангийн бактерийн эсрэг идэвхийг тогтоосон, антибиотик төст үйлдлийг судалсан судалгаа бараг хийгдээгүй байгаа болно.

Иймд бид өөрийн Уламжлалт анагаахын Эмийн үйлдвэрт үйлдвэрлэгдэж байгаа эм, тангуудын антибиотик төст үйлдлийг шинжлэх ухааны үүднээс судлан тогтоож практик хэрэглээг сонгомол болгон өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Энэ зорилгын үндсэн дээр бөөрний илч буурсан, бэтэг, цайвар хаван, суваг хаван, дусал цувирах, шээс хаагдах, бөөр бэлхүүсээр өвдөх, хэрх, суулгах, ходоодны галын илч буурсныг анагаахад өргөн хэрэглэж ирсэн олон өвчний эсрэг сонгомол үйлчилгээтэй Сожид-11 талх эмийг сонгон авч түүний антибиотик төст чанарыг судаллаа.

Сожид-11 эм нь бор шаргал өнгөтэй, гашуувтар эхүүн амттай талх эм. Монголын уламжлалт анагаах ухаанд энэ эм нь ходоод, бөөрний илчийг үүсгэх, шар усыг хатаах, шингээлтийг сайжруулах, хаванг арилгах чадалтай.

**SUMMARY**  
**STUDY OF ANTIBIOTIC LIKENESS OF THE “SOJID-11”**

**Tuguldur.A, Narangerel.B**

Traditional Medical Science Technology and Production Corporation,  
Veterinary Institute

The usage and manufacturing of naturally-extracted and traditional medical cures and drugs are growing constantly in recent years in our country. There is increased demand for testifying safeness, effectiveness and quality of traditional cures and drugs. However, report on determining of anti-bacterial resistances and antibiotic likeness properties for those drugs almost doesn't exist.

Thus, in order to determine the antibiotic-likeness properties of traditional cures and drugs from scientific perspectives and to extend practical usage into selected ones, we have cure called Sojid-11 which has selective effects for many diseases.

*E.Coli* strains were used in this study.

Virulence, stain, morphology, cultivation, growth character, sanitization were determined by common bacteriological methods while antibiotic-likeness property was made by several variations of disc method.

Outcome of this study reveals that the specimen of Sojid-11 was sterile and it doesn't show any antibiotic-likeness properties to obstacle growth or exterminate of the *E.Coli* strains.

## БООМЫН НЯН (*BACILLUS ANTHRACIS*)-ИЙН ЭСРЭГ ХАР МОД (*LARIX SIBIRICA* Ldb.)-НЫ МӨЧРИЙН ИДЭВХТ НЭГДЛИЙН СУДАЛГАА

П.Эрдэнэбаатар, Ж.Батхүү, Д.Ганболд, Ш.Оюунцэнэг,  
Д.Отгонбаатар, Д.Цэрэнноров, Г.Одонтуяа

ШУА, Биологийн Хүрээлэн, МУИС, Биологи-Биотехнологийн Сургууль  
Байгалийн Голомтот Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв  
ШУА, Хими-Хими Технологийн Хүрээлэн

### Abstract

The methanol extract and its water nonsoluble fraction of the stem of *Larix sibirica* Ldb. exhibited a good inhibition activity against *M.luteus* strain and anthrax causal pathogen *B.anthraxis* 90, 120, 147, 178 by the disc diffusion method. Activity-guided isolation of the water nonsoluble resin fraction led to the isolation of isopimaric acid which molecular structure was determined by <sup>1</sup>H, <sup>13</sup>C NMR spectroscopy and MS methods. Isopimaric acid exhibited a potential activity against *M.luteus* bacterial strain (9.5 mm) and *B.anthraxis* 90 –17 mm, 120–15 mm, 147–15 mm, 178–17 mm, respectively.

**Түлхүүр үг:** *Larix sibirica* Ldb., *Bacillus anthracis*, изоимарын хүчил

### Хураангуй

Хар мод *Larix sibirica* Ldb./-ны мөчрийн метанолон ханд, түүний усанд уусдаггүй, туйлгүй давирхайлаг фракц нь *S.aureus*, *E.coli*, *M.luteus* нянгуудын өсгөвөр, боом өвчнийг үүсгэгч *B.anthraxis* 90, 120, 147, 178 нянгийн өсөлтийг дарангуйлах идэвхтэй болохыг цаасан дискийн аргаар өмнө нь бид тодорхойлсон билээ. Энэ удаад бид боомын нянгийн өсөлтийг дарангуйлах идэвхтэй давирхайлаг фракцаас, идэвхтэй нэгдэл изоимарын хүчлийг хроматографын аргуудаар цэврээр ялгасан ба түүний молекулын бүтцийг <sup>13</sup>C болон <sup>1</sup>H ЦСР, МС аргуудаар тодорхойлов. Изоимарын хүчил нь анхан шатны тест микроорганизм болох *M.luteus* дээр 9.5 мм, боом үүсгэгч *B.anthraxis* 90 омог дээр 17 мм, 120 омог дээр 15 мм, 147 омог дээр 15 мм, 178 омог дээр 17 мм ариун бүсийг үүсгэн тэдгээрийн өсөлт хөгжилтийг дарангуйлах идэвхийг үзүүлж байлаа.



## ОЛОН ЦЭЦЭГТ СУХАЙ (*TAMARIX RAMOSISSIMA* L.)-Н БИОЛОГИЙН НӨӨЦИЙГ БИОТЕХНОЛОГИЙН АРГААР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ

Ц.Мөнхцэцэг, Ю.Оюунбилэг

ШУА, Биологийн хүрээлэн, Ургамлын эсийн өсгөврийн лаборатори  
И-мэйл: Munkhuu003@yahoo.com

**Товчлол:** Энэ судалгаагаар Олон цэцэгт сухайн *in vitro* өсгөвөр эхлүүлэх, бичил ургамал гарган авч, улмаар *ex vitro* (хүлэмж)-д шилжүүлэх зорилгоор 5 настай дээж ургамлын найлзуураас үе зайдмыг эксплантаар сонгон авч ауксин, цитокининий зарим төрлийн гормон хэрхэн нөлөөлөхийг туршиж үзсэн. Үе зайдмаас шинээр нахиа үүсгэхэд 2.2µM БАП, 0.57µM НЦХ-тэй, 4 дахин шингэрүүлсэн Мурациге-Скуг (МС) тэжээлийн орчин илүү тохиромжтой байсан. Бичил ургамлыг үндэслүүлэхэд 1/4 МС үндсэн тэжээлийн орчинд 2.4-Д (0.45µM, 2.26 µM, 4.52 µM), НЦХ(0.57 µM, 2.85 µM, 5.71 µM), ИБХ (0.49 µM, 2.46 µM, 4.90 µM), ИЦХ(0.57 µM, 2.85 µM, 5.71 µM), зеатин (0.46 µM, 2.28 µM, 4.56 µM), кинетин (0.46 µM, 2.32 µM, 4.65 µM)-ийг өөр өөр концентрацитай нэмж туршсан. Туршилтын үр дүнгээс үзэхэд 0.57µM НЦХ, 0.49µM ИБХ нэмсэн МС орчин үндэс үүсгэхэд эерэгээр нөлөөлж байсан. Харин 0.57µM НЦХ-ийг дангаар нэмсэн үед нахианы өсөлт сайжирсан ч үндэс нь богинохон, цагаан өнгийн каллус үүсгэж, *ex vitro*-д шилжүүлэхэд хорогдол ихтэй байсан. Гэвч 0.49µM ИБХ нэмсэн тэжээлийн орчинд нахианы өсөлт сайжирч, олон салаалсан үндэс үүсгэсэн. 6-8 долоо хоногтой сайн үндэслэсэн бичил ургамлыг *ex vitro*-д (хүлэмж) шилжүүлж амьдрах чадварыг үнэлэх болон навчны анатомийн судалгааг эхлүүлээд байна.

**Түлхүүр үг:** *Tamarix ramosissima* L., үе зайдам, *in vitro*, бичил ургамал, *ex vitro*

### SUMMARY RUST DISEASE RESISTANCE GENELOGY BREEDING FOR DISEASE

I.Dagiimaa

Plant science and research training institute

According to the research we shortened the period of breeding for disease resistance even the each crop breeding varieties, developed technology for selection accuracy improvement and rust disease monitoring marker gene transfer. It means the theoretical level of breeding research has increased by one step. The brown rust disease research study has not done yet in Mongolia.

It has good resistance in the 9<sup>th</sup> ras which dominated in the world determined as Lr 47 gene 22 genes by the research of Helgueva M., Khan I.A, Dubcovsky (2000). It has good resistance for all combination hybrid genesis when comparing the parent Mongolia varieties to the hybrid F<sub>1</sub> genesis as Lr 47.

Reason of that there's dominated hybrid genesis and the brown rust disease resistance rasis as Lr 47 gene in Mongolia.

## ДУНДАД ХАЛХЫН ХЭЭРТ УРГАМЛЫН БҮРХЭЦ, ТОХИОЛДОЦ, ЗҮЙЛИЙН БҮРДЛИЙГ ДАУБЕНМАЙРЫН АРГААР ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

(Төв аймгийн Баян, Баянцагаан сумын жишээн дээр)

И.Сарангэрэл

Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв

**Товчлол:** Монгол орны эрс тэс уур амьсгал, газарзүйн хэв шинж хотгор гүдгэр, тал, хөндий ихтэйн улмаас олон янзын ландшафт үүсдэг. Мөн тэдгээр ландшафтад тохирох ургамалан бүлгэмдлийн бүрэлдэхүүнийг тодорхойлдог олон арга зүй байдаг боловч энгийн, хялбар, оновчтой, аль ч бүлгэмдэлд таарч тохирох аргыг одоог хүртэл судлаач нар эрэлхийлсээр байгаа билээ. Даубенмайрын арга нь хэрэглэхэд энгийн, статистикийн хялбар арга ашиглагдаж байгааг тооцоо гаргадагаараа онцлог бөгөөд манай оронд бараг ашиглагдаж байгаагүй. Иймд Төв аймаг дахь санамсаргүй аргаар сонгон авсан талбайдын ургамлын бүрхэвчийн онцлогийг бага зардлаар богино хугацаанд гаргахын тулд Даубенмайрын аргыг туршихыг зорилго болгон судалгааг гүйцэтгэн, судлав.

**Түлхүүр үг:** Даубенмайрын арга, ургамал, бүрхэц, тохиолдоц, зүйлийн бүрдэл.

## БЭЛЧЭЭРИЙН МОНИТОРИНГИЙН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС (Ойт хээрийн бүс)

Ж.Гантуяа  
М.А.А.Э.Ш.Х.

И-мэйл: gant\_416@yahoo.com

**Товчлол:** Бэлчээрийн эдэлбэр газрын тогтвортой байдал нь түүний чанарын үзүүлэлт урт удаан хугацаанд хэвийн хадгалагдах нөхцлөөр тодорхойлогдох бөгөөд түүнийг бэлчээрийн мониторингийн судалгаагаар илрүүлнэ. Иймд бид ойт хээрийн бүсийг төлөөлүүлэн Сэлэнгэ аймгийн 3 сумдад (Ерөө, Баянгол, Жавхлант) нийт 6 мониторингийн цэгийг сонгон энэхүү судалгаагаа 2009-2011 онд хийлээ. Бэлчээрийг давтан хэт ачаалалтай ашиглахад ургамлын зүйл хомсдон, ургац буурч, идэмж муутай ургамал түрэн ургаж, хоосон орон зайн хэмжээ нэмэгдэн бэлчээр доройтолд орж бүтээмж нь 2-3 дахин буурч байна. Мөн бэлчээрлэх зай алслахад ургацад эзлэх үетний хувь өссөн үзүүлэлт харагдаж байгаа боловч мөн түүнийг дагаад алаг өвсний хэмжээ бууралт үзүүлээгүй байгаа нь бэлчээрийг байгалийн аясаар нөхөн сэргэхэд амрах болоод сэлгэх үйл явц үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна. Харин бэлчээрлэх зай ойртоход ургацад эзлэх үетний хэмжээ буурч, буурцагтан ургамал бүртгэгдэхгүй байгаа нь бэлчээр доройтож байгааг илтгэнэ.

**Түлхүүр үг:** Зүйлийн бүрэлдэхүүн, бүтээмж, бэлчээрийн даац, бэлчээрийн доройтол, нөхөн сэргэлт

**SUMMARY**  
**“LONG TERM MONITORING OF RANGELAND”**  
**(IN FOREST STEPPE CASE)**

**J.Gantuya**

Research Institute of Animal Husbandry,  
 E-mail: gant\_416@yahoo.com

The representative sites were selected in forest steppe zone. It was main camping-settlement points of livestock. At each site, five paired plots were laid out, representing typical slopes and main vegetation types. These distances (middle, fair) was from camping-settlement points. The grazing pressure changed the primary characteristics in plant community structure. The surface layer and nutrient were lost in the overgrazed areas and invasive weeds were increased. The percentage of unpalatable and lower value herbs such as *Artemisia adamsii*, *Carex duriuscula* and *Salsola collina* predominated. The yield was decreased by 2-3 time in fair camping area. Over grazing reduced the permanent grasses and their capability to recover. Grasses were replaced by shallow-rooted, annual plants of inferior grazing value. A proper balance between the number of the livestock and available forage must be maintained by continuous and careful observation of the vigour of grasses on the pasture. Many species are surviving under poor conditions. The summer camping area's vegetation structure and soil properties changed by the actual grazing intensity.

**МОНГОЛ ОРНЫ ЗАРИМ ЗҮЙЛ УРГАМЛЫН МУТАГЕНИЙ**  
**БОЛОН БАКТЕРИЙН ЭСРЭГ ИДЭВХИЙН СКРИНИНГ**  
**СУДАЛГАА**

**Ж.Удаахбаяр, Ч.Батцэцэг, Ж.Батхүү**

Монгол Улсын Их Сургуулийн Биологи Биотехнологийн Сургууль  
 И-мэйл: Udaah\_09@yahoo.com

**Товчлол:** Хүрээлэн буй орчны бохирдол, баталгаагүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэгтэй холбоотойгоор манай оронд өвчлөгсдийн тоо буурахгүй байна. Бид энэхүү судалгаагаар Монгол орны 13 зүйл эмийн ургамлын 20 хандны мутагений болон бактерийн эсрэг идэвхийг тогтоов. Мутагений эсрэг идэвхийг Эймсийн сорилоор, тест бичил биетэн болох *Salmonella typhimurium* TA1537, стандарт мутаген 9-аминоакридинийг хэрэглэн тодорхойллоо. *Achillea asiatica*-ийн газрын дээд хэсэг 79.6%, *Amethystea caerulea* L-ийн цэцэг, навч 63.6%, үндэс 68.1%, иш 59.7%, *Arabis pendula* L.-ийн иш 44.3%, *Agrimonia pilosa* .-ийн иш 78.7 %, *Abies sibirica*.-ийн навч 59.7, *Carduus crispus* L-ийн иш 75%-иар стандарт мутаген 9-аминоакридины үйлчлэлийг хамгийн ихээр дарангуйлж байв. Бактерийн эсрэг идэвхийг цаасан дискийн аргаар тест бичил биетэн болох *S.aureus*, *E.coli*, *M.luteus*, *E.faecalis* ашиглан тодорхойлсон. *Agrimonia pilosa*-ийн иш, *Abies sibirica*.-ийн навч, *Chelidonium majus*-ийн иш, *Dasiphora fruticosa* (L.)- ийн газрын дээд хэсэг, *Dasiphora parvifolia*-ийн цэцэг, навч 10 мг/мл концентрацидаа тест бичил биетнүүдийн өсөлтийг ихээр дарангуйлж байв.

Бид цаашид дээрх ургамлуудаас мутагений болон бактерийн эсрэг идэвхтэй нэгдлүүдийг илрүүлэх, цэврээр нь гарган авах, тэдгээрийн молекулын бүтэц, байгууламжийг тогтоох зорилт тавин ажиллаж байна.

**Түлхүүр үг:** ургамал, антимутаген, антибактер идэвх

### **SUMMARY**

We have examined the anti-mutagenic effects of 20 extracts, which prepared from different parts of 13 plants species. The anti-mutagenic tests were performed as described by Ames. The bacterium used in the test is a strain of *Salmonella typhimurium* TA1537, and using 9-aminoacridine as direct mutagen. From the 20 plant extracts studied, extracts (10% DMSO) of *Amethystea coerulea* (stem, root, leaf+flower) and *Carduus crispus* L. (stem) strongly inhibited mutagenicity of 9-aminoacridine and tested them for antibacterial activity in vitro using disk diffusion method. As result of the research, the extract of *Dasiphora fruticosa* (L.) areal part and *Abies sibirica* leaf showed activity in 10 mg/ml.

Our research results show that Mongolian medicinal plants have an antimutagenic and antibacterial activity, it also justified of their traditional use. Detailed investigation is needed to isolate pure bio-active compounds from high active plants and determine their chemical structures as well as to make it accessible to modern clinical practice.

**Acknowledgements:** This research was supported, in part, by The Honda Foundation, Japan. We wish to acknowledge the kind generosity of Professor Fumio Kato (Faculty of Pharmacognosy, Toho University, Japan) in providing *Salmonella typhimurium* TA1537 and other chemicals. The authors are grateful to professor F.Yoshizaki and Mr. T.Murata of Tohoku Pharmaceutical University for NMR and MS analyses (measurements).

## ДӨРВӨЛЖИН СУМ ОРЧМЫН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ТЭДГЭЭРИЙГ ХУУРАЙШИЛТЫН ИЛТГҮҮРТ АШИГЛАХ НЬ

Х.Солонго

Ботаникийн хүрээлэн, Ургамлын аймаг, ангилалзүйн салбар  
И-мэйл: khadaas@yahoo.com

**Товчлол:** Завхан аймгийн Дөрвөлжин сумаас хойшоо 50 км Баян-Айраг хэмээх далайн түвшингээс 1600-1800 м-ийн өндөрт орших галт уулын гаралтай чулуулгаас тогтсон нам уулс, өмнө талаас Монгол элсний нөлөө орсон элсэн хөрстөй нутгийн 5.3 га талбайг сонгон авсан. Судалгааны дүнд нийт 29 овгийн 75 төрлийн 111 зүйл дээд ургамал бүртгэгдсэнийг экологийн бүлгээр ангилахад чулуусаг хуурайсаг 49 %, чийгсүү давссаг 11% , хуурайсаг давссаг 16%, элссэг 22% байлаа. Өмнөх судлаачийн дүнтэй харьцуулахад чулуусаг хуурайсаг 30%, чийгсүү давссаг 15%, хуурай давссаг 5%, элссэг 16% тус тус ихсэн өөрчлөлтийг харуулж байна.

**Түлхүүр үг:** Ердийн трансект, экологийн бүлэг, зүйлийн бүрдэл.

**Оршил:** Сүүлийн үеийн дэлхий нийтийн тулгамдсан асуудал болох хуурайшил, хэт дулаарал нь манай орны зарим нутгийн ургамлын олон янз байдалд сүүлийн 20-30 жилийн дотор онцгой өөрчлөлт оруулж байна. Завхан аймгийн Дөрвөлжин сум нь ургамал газарзүйн тойргоор голарктикийн их муж, эртний газар дундын тэнгисийн дэд муж, иран тураны муж, Төв Азийн хээр цөлийн дэд муж, Монголын хээр цөлийн хошуу, умард говийн цөлөрхөг хээрийн дэд хошуу, их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна (Өлзийхутаг,1989). Энэ нутгийн ургамлын зүйлийн бүрдлийг 30-аад жилийн өмнө ахмад судалаач Х.Буян-Орших экологийн бүлэгтэй нь гаргасан байдаг. Бидний судалгааны зорилго тухайн нутгийн ургамлын зүйлийн бүрдэл энэ хугацаанд хэрхэн өөрчлөгдөж байгааг хуурайсаг ургамлын зүйлийн бүрдлээр тодорхойлно.

### *SUMMARY*

#### **USING PLANT SPECIES COMPOSITION AS AN INDICATOR DRIED CLIMATE CHANGE IN DORBOLJIN SUM, ZAVKHAN**

**Key words:** regular transect, ecology group, species composition.

We have selected 5.3 hectare area of Bayan-Airag that located in 50 km from Durvuljin soum, Zavkhan aimag. The Bayan-Airag study area is located in sandy covered volcanic hills that elevated 1600-1800 meter a.s.l. As a result of the study, 111 vascular plant species that belong to 75 genera of 29 families. According to the ecological group classification, 49 percent of them petro-xerophytic, 11% hygro-halophytic, 16% xero-halophytic and 22% psammophytic were recorded, respectively.

## БУЛГАН АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН УРГАМЛАН НӨМРӨГИЙН ДОРОЙТОЛ

Н.Итгэлт, А.Хауленбек,

Геоэкологийн хүрээлэн Цөлжилтийн судалгааны төв,

И-мэйл: Itgelt\_2006@yahoo.com

**Оршил:** Цөлжилт, газрын доройтлын үйл явц нь өнөөдөр дэлхийн 100 гаруй оронд илэрч, олон улсын хэмжээнд тулгамдаж буй экологийн бүлэг асуудлын нэгд зүй ёсоор багтах болсон байгаль, нийгэм, эдийн засгийн хавсарсан нөлөөнд явагддаг экологийн үйл явц юм. Цөлжилтийн үйл явц нь уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдолт, биологийн төрөл зүйлийн хомсдол зэрэг асуудлуудтай эн тэнцүү хэмжээнд тавигдах болсон.

Цөлжилтийн үйл явц нь байгаль, нийгмийн хавсарсан үйлчлэл хүрээнд явагдах бөгөөд уур амьсгалаас үүдэлтэй байгалийн экосистемийн доройтлыг бууруулах боломж хүн төрөлхтөнд бараг үгүй юм. Харин хүний үйл ажиллагааны сөрөг үр дагаврыг бууруулах, байгалийн нөөц ашиглалтыг зүй зохистой тогтолцоонд шилжүүлэн шинэчлэх нь цөлжилттэй тэмцэх бодит боломж юм. Манай орны хувьд төв суурин газруудын ойр орчмын бэлчээрт хэт ачаалал өгснөөр элсжих нөхцөл бүрдэж байна. Түүнчлэн хот төлөвлөлт хийгддэггүйгээс төв, суурин газруудад ногоон байгууламжийн талбай хумигдаж байна.

### SUMMARY

The research documents the patterns of vegetation degradation in and around settled areas of steppe region in Mongolia. For this research Arkhangai aimag and Bayannuur soum. To assess the vegetation degradation, vegetation canopy, plant height and biomass were measured as primary indices. The surveys conducted at distances of 0, 5 and 10 km from settled areas. Results indicate that the vegetation canopy in within the settlement varies between 2- 5%, while in distance of 5 km from the settlement it increases by 13.2-48.9%. The survey showed that the vegetation canopy at 10 km from settled areas increased up to 31.2- 54.6%. This shows that the vegetation within settled areas is more degraded when compared to the distant areas. The same results were found with height and biomass of plants, which means the degradation of vegetation cover are much higher in settled areas due to the highly concentrated technogenic disturbances compared to grazing areas. The research also focuses on revealing areas where degradation is rapidly progressing. According to the research results in radius of 2.5 km around the settlements the degradation is more intensive, leading to an increase of barren lands and aggravating the sand movement. Within this area the vegetation cover mainly represented by such weed plants as *Artemisia adamsii*, *Potentilla anserina*, *Chenopodium album* etc.

## МОНГОЛ ОРНЫ *CETRARIA ISLANDICA* (L) ACH. ХАГИЙН ЗАРИМ БАКТЕРИЙН ЭСРЭГ ИДЭВХИЙН СУДАЛГАА

Г. Мөнхцацрал, Б. Мөнхжаргал

<sup>1</sup>ШУТИС-ийн Хүнсний Инженер Биотехнологийн Сургууль,

<sup>2</sup>ШУА-ийн Ботаникийн Хүрээлэн

И-мэйл: gmunkhtsataral@yahoo.com

**Товчлол:** Бид Монгол орны *Cetraria islandica* (L) Ach. хагийн биохими, микробиологийн зарим үзүүлэлтүүдийг тодорхойлж, биологийн идэвхт бодис болон зарим бактерийн эсрэг үйлчилгээг судлах, хүнс болон эм, антибиотикийн оронд хэрэглэх боломжтой эсэхийг тогтоох зорилгоор тус хагийг ус болон спирт, органик уусгагчдад хандлан түүний бактерийн эсрэг үйлчилгээг параллель зураасан арга, цаасан дискийн арга, дэс дарааллан шингэрүүлэлтийн арга болон нэвчих/нүхлэх аргыг ашиглан тодорхойллоо. Мөн *Cetraria islandica* хагны усний хүчлийн агууламжийг орчин үеийн дэвшилтэт Нил Улаан туяаны спектроскоп болон хроматографийн аргаар тодорхойлсон. Үүнд органик уусгагч ашиглах үед хагны бактерийн эсрэг үйлчилгээтэй бодисууд илүү сайн хандлагдаж байсан ба ус болон спиртэн хандны бактерицид шинж чанарыг параллель штрихийн аргаар тодорхойлоход гэдэсний савханцар *Escherichia coli*-г бүрэн дарангуйлж байна. Харин хлороформ, бензолын 9 өөр харьцаатай органик уусгагч дахь *Cetraria islandica* хагийн бактерийн эсрэг үйлчилгээг цаасан дискийн болон дэс дарааллан шингэрүүлэлтийн аргаар тодорхойлж үзэхэд 2:8, 3:7 харьцаатай ханднууд нь сонгон авсан зарим бактерийн ургалтыг дарангуйлах чадвараар сайн байсан ба антибиотикийн үйлчлэл бүхий бодисын тэжээлт орчинд нэвчих чадварт үндэслэж зарим бактерийн эсрэг идэвхийг тодорхойлоход 3:7, 7:3, 9:1 харьцаатай ханднуудад антибиотик төст нэгдлүүд илүү сайн ялгарч, сонгож авсан зарим бактерийн ургалтыг дарангуйлж байсан. Хлороформ, бензолын 9 өөр харьцаатай органик уусгагчдад бэлдсэн хандны бактерийн эсрэг үйлчилгээг 3 аргаар тодорхойлоход хамгийн тохиромжтой харьцаа нь 3:7 байсан ба бензолын харьцаа нэмэгдэх тусам түүнд хандлагдах биологийн идэвхт бодис нь ихэсч, бактерийн эсрэг идэвх үзүүлж байгаа нь тогтоогдлоо.

Дээрх үр дүнд тулгуурлан талх, талхан бүтээгдэхүүнийг *Cetraria islandica* хагаар баяжуулахад хадгалалтын хугацаа 5-6 хоног уртасч байсан ба химийн үзүүлэлтээрээ сийрэгжилт, хөөлтийн хэмжээг нэмэгдүүлж байсан. Иймд бидний судалгаа *Cetraria islandica* хагийг хоол хүнсэндээ нэмэлтээр оруулах, зарим төрлийн бактериар өдөөгдөх өвчний эсрэг хандлан хэрэглэх бүрэн боломжтойг харуулж байна.

**Түлхүүр үг:** Исланд хөвдөл (*Cetraria islandica* (L) Ach.) хаг, бактерийн эсрэг үйлчилгээ, дарангуйлах чадвар



**SUMMARY**  
**THE STUDY ON ANTIBACTERIAL ACTIVITIES OF LICHEN**  
***CETRARIA ISLANDICA* (L) ACH. OF MONGOLIA**

**Munkhtsatsral G., Munkhjargal B.**

School of Food Engineering and Biotechnology, The Mongolian University of  
Science and Technology

Institute of Botany, Mongolian Academy of Sciences

E-mail: gmunkhtsatsral@yahoo.com

In this study, we determined the antibacterial activities of *Cetraria Islandica* (L) Ach by extracting it in aqueous, alcohol (70%) and organic (chloroform, benzene) solvents using four different methods: parallel linear method, paper disc method, sequence dilution and diffusion method. Also the content of usnic acid of *Cetraria islandica* has been determined by infrared spectroscopy and chromatography methods, the most advanced modern ultra violet ray method.

In the application of organic solution the substances counteracting bacteria are readily soluble as well as in determining the antibacterial properties of aqueous or alcohol solution by the method of parallel linear it completely suppressed the stomach bacilli *Escherichia coli*. But in determining the antibacterial activity of *Cetraria islandica* in organic solution with 9 different ratio of chloroform and benzene using the methods of paper disc and sequence dilution the extract with ratio 2:8, 3:7 has a good property to counteract the growth of some bacteria. When we have identified the antibacterial activities basing on the ability of substances to diffuse into the nutrition environment with the effect of antibiotics, in the extracts with ratio of 3:7, 7:3 and 9:1 compounds similar to organics is released well and knocked off the growth of some chosen bacteria. During the determination the antibacterial activities of extracts prepared in organic solutions with 9 different ratios of Chloroform and benzene the most optimal ratio was 3:7. With increasing ratio of benzene the biologically active substances have been more increased and have more activities antibacterial.

On the base of the above result we were able to extend the storage life of bread and pastry for 5-6 days and increase the amount of fermentation by chemical indicators. As our research shows there is a full possibility to use *Cetraria islandica* as supplemental additional food and consume its extract against some diseases caused by some kinds of bacteria.



**ЦЭНХЭР ШААЗГАЙН (*Cyanopica cyanus* Pallas, 1776) ҮРЖИЛ,  
ТҮҮНД ОЙН ТҮЙМЭР, ЗАРИМ АМЬТДААС ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**

**Б.Гантулга, С.Гомбобаатар, Kerry-Jayne Wilson, Michael Muehlenberg**  
МУИС, Биологийн факультет, Шувуу судлалын лаборатори,  
Ecology Department, Lincoln University, P.O. Box 84, Lincoln, New Zealand  
<sup>3</sup>Centre for Nature Conservation, University of Geottingen, Germany  
И-мэйл: B.Gantulga\_mos@yahoo.com, info@mos.mn

**Товчлол:** Бид цэнхэр шаазгайн (*Cyanopica cyanus*) үржлийн амжилт болон туслах зан төрхийн өөрчлөлтийг харьцангуй тусгаарлагдмал үржлийн бүлд гурван үржлийн улирлын турш мах идэшт зарим амьтад, ойн түймэр зэрэг хүчин зүйлийн нөлөөтэй харьцуулан судлав. Хээрийн судалгаа Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал сумын нутагт орших “Хонин нуга” судалгааны суурин (49°05'N; 107°17'E)-д 2007-2011 оны 5-8-р сард үргэлжилсэн юм. Үржлийн хос, үүрний туслагч болон үүрэнд ирэгч бусад бодгалиудыг тогтоох, эдгээрийн эм шувууд, ангаахайнуудыг хооллох онцлог, үржлийн хосуудын үүрэнд эзгүй байх хугацаа, махчдын эсрэг үзүүлэх хариу үйлдэл болон бусад үржлийн зан төрхийг тогтоохын тулд ажиглалтыг гүйцэтгэлээ.

Цэнхэр шаазгайн үржлийн амжилт 2007 онд 63% (n=49), 2008 онд 47% (n=41), 2009 онд 30% (n=23), 2010 онд 61% (n=23) ба 2011 онд 95% (n=35) (Kruskal-Wallis,  $H_4 = 10.09$ ,  $P = 0.03$ ) байлаа. Цэнхэр шаазгайн үржлийн үеийн идэш тэжээл болох өрөөсгөл хүр эрвээхийн бараг бүх авгалдай, бусад шавжуудыг 2009 оны ойн түймэр хөнөөв. Туслагчтай үржлийн эр бодгалиудын 2009 онд ангаахайгаа хооллох эрчим нь 2008 оныхоос даруй хоёр дахин бага (Wilcoxon,  $Z=2.87$ ,  $p<0.004$ ). Үржлийн бус болон үржих оролдлого нь бүтэлгүйтсэн зарим шувууд туслагчид болон хувирч, 2009 оны идэш тэжээл дутмаг үржлийн улиралд үржлийн эр бодгалиудын гүйцэтгэж хүчрэхгүй байсан үүргийг хамтран гүйцэтгэсэн буюу ангаахайг зайлшгүй шаардлагатай тэжээлээр таслалгүй хангаж байв. Энэ хүчин зүйлийн нөлөөгөөр ангаахайнууд өлсгөлөнд бага өртөж, амжилттай бойжсон билээ. Амьтдын нөлөөгөөр сүйдсэн үүрний тоо 2008 онд харьцангуй олон (19 үүрнээс 9) хэдий ч, хүрэлцээтэй идэш тэжээлтэй үед туслах зан төрх 176 цагийн ажиглалтын үед зөвхөн 2 удаа тэмдэглэгдэв. Гэтэл 2009 онд олдсон 14 үүрний 4 нь бусад амьтдын нөлөөгөөр, 4 нь ойн түймэрт сүйдсэн бол 1 үүрний ангаахайн өлсөж энджээ. Туслах зан төрхийн 100 тохиолдол нийт 132 цагийн ажиглалтаар илрэв. Туслагчтай үүрнүүдийн ангаахайн тоо туслагчгүй үүрнүүдийн ангаахайн тооноос мэдэгдэхүйц олон (Mann-Whitney test:  $U=2$ ,  $n_1=4$ ,  $n_2=6$ ,  $P=0.02$ ), мөн туслагчтай үүрнүүдийн үржлийн амжилт туслагчгүй үүрнүүдийнхээс эрс өндөр байв (Mann-Whitney test:  $U=20$ ,  $n_1=4$ ,  $n_2=5$ ,  $P=0.009$ ). Эдгээр үр дүн нь нэг талаар туслагчид ангаахайн мэнд үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг батлав.

**Түлхүүр үгс:** Цэнхэр шаазгай, *Cyanopica cyanus*, үржил, туслах зан төрх, махчлал, ойн түймэр

**SUMMARY**  
**IMPACTS OF FOREST FIRE AND PREDATION TO THE**  
**BREEDING BIOLOGY OF AZURE-WINGED MAGPIE (*CYANOPICA***  
***CYANUS PALLAS, 1776*), MONGOLIA**

**Gantulga.B., et al**

<sup>1</sup>Ornithological laboratory, Faculty of Biology, National University of Mongolia and  
E-mail. B.Gantulga\_mos@yahoo.com, info@mos.mn

We studied the breeding performance and helping behaviour of Azure-winged magpie's (*Cyanopica cyanus*) isolated breeding colony in three breeding seasons with high nest predation and major forest fire. Breeding success was 63% (n=49) in 2007, 47% (n=41) in 2008 and 30% (n=23) in 2009, 61% (n=23) in 2010 and 95% (n=35) in 2011 (Kruskal-Wallis,  $H_4 = 10.09$ ,  $P = 0.03$ ). High inverse relevance was found between the average number of larva of Gypsy moth and number of helpers in years. Helping behaviour strongly instigated after forest fire and helpers greatly played important role for breeding performance. Comparison of nests with and without helpers showed that helpers played the significant role to number of fledglings. In fact, the helpers improved the survival of nestlings and breeding success of our study colony. A total of two occasions of helping behaviour was observed for 176 hours observation in 2008 whereas, 100 helping behaviour was recorded for 132 hours observation in 2009. There was no difference on predation between 2008 and 2009. It clearly shows that nest predation was not associated with helping behaviours for this colony. Comparison of data from 2008 and 2009 showed that the frequency of feeding to nestlings from males in 2009 was shorter than 2008 due to deficiency food and helpers' assists recovered it (Wilcoxon,  $Z = 2.87$ ,  $p < 0.004$ ). The nest failures without helpers were highly associated with nest predation (3 of 4) and starvation of nestling (1 of 4). However, only one nest (1 of 7) with helpers was failed by predators. In the result of efficiency of helpers, breeding success of the nests with helpers was high because of protection from predators and food delivery which give an opportunity to females to spend more attention for their nests. We very appreciated Prof. Michael Muchlenberg, manager A.Enkhmaa, Goettingen University, Germany, Kerry-Jayne Wilson, Lincoln University, New Zealand and Mongolian Ornithological Society for their advice and financial supports. We would like to express our thanks to Mrs. Susan Sloan, Mr. Chris Leahy of Mass Audubon Society, USA and Mongolian Ornithological Society for their incredible supports of field equipments and encouragements.

**МОНГОЛ ОРНЫ ДОРНОД ХЭСГИЙН ХОШУУ ГАЛУУНЫ (*Anser cygnoides* L., 1758) ҮРЖЛИЙН ҮЕИЙН ЭКОЛОГИ, НҮҮДЭЛ****Ц.Мөнхзул**

Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

**Товчлол:** Монгол оронд хошуу галууг нарийвчлан судалсан судалгаа байдаггүй бусад судалгааны явцад тоолж бүртэгсэн бүртгэлийн мэдээ баримтууд байдаг. Тиймээс энэ судалгаа нь Монгол орны зүүн хэсгийн хошуу галууны биологи, экологийн судалгааг нарийвчлан хийсэн. Нуур болгон дээр тоо толгойн бүрэлдхүүнийг гаргаж, бие гүйцсэн шувууд болон дэгдээхэйг бариж морфологийн хэмжилгүүдийг хийж, бие гүйцсэн шувуудад сансарын долгион дамжуулагч зүүж нүүдлийн зам болон өвөлждөг газрыг тогтоож өгсөн. Монгол орны зүүн хэсгийн хошуу галуу нь Хятад, Хойд Солонгос хоёрын хилийн зааг Ялуу голын адаг хэсгээр дайраад Хятадын Чанхай нууранд очиж өвөлжиж байна.

**Түлхүүр үг:** Хошуу галуу, тоо толгой, амьдрах орчин, морфологийн хэмжилт, нүүдэл

## A POSSIBILITY TO DETERMINE THE AGE OF MONGOLIAN WILD ASS (*EQUUS HEMIONUS PALLAS, 1775*) BY ANNUAL RINGS IN TOOTH CEMENTUM

D.LKHAGVASUREN<sup>1</sup>, H. ANSORGE<sup>3</sup>, N. BATSAIKHAN<sup>2</sup>, R. SAMIYA<sup>2</sup>, A.STUBBE<sup>4</sup> AND M.STUBBE<sup>4</sup>,

